



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/20.

Пионер толгой

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээт
дуудлага худалдаа зохион байгуулах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Газрын тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Гурванбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2022 оны “ Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөө батлах тухай” 10/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээт дуудлага худалдааг хавсралтад дурдсан байршлуудад зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Отгончимэг	Гурванбулаг сумын Газрын даамалын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Б.Дэлгэрдалай Ш.Нархүү	Тамгын газрын нягтлан бодогч Байгаль орчны улсын байцаагч

2.Дахин дуудлага худалдааг 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж дуудлага худалдаа явуулсан үр дүнг дуудлага худалдаа явуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан Засаг даргын удирдлагын багт танилцуулахыг дуудлага худалдааны комисст даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



Сумын Засаг даргын 1023 оны
07 дугаар сарын 30-ны өдрийн
А/20 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭТ ДУУДЛАГА
ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН ЖАГСААЛТ

№	Баг	Байршил	Зориулалт	Талбайн хэмжээ /м2/	Дуудлага худалдаа- ны анхны үнэ/төг/	Дэнчин /төг/	Дуудлага худалдаа явуулах он сар өдөр
1	Пионер толгой 5 дугаар баг	Цэнгэлдэх хүрээлэнгийн зүүн урд талд	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж бусад газар	423	270.720	27072	2023.07.24
2	Хөвийн ам 4 дүгээр баг	Хөвийн ам 4 дүгээр баг Тэмээн хүзүү	Аялал, жуулчлалын бааз	20006	16.004.800	1.600.480	2023.07.24

_____оОо_____